



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2015 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 5/54

Улаанбаатар хот

Шилжүүлэн ажиллуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, Засгийн газрын 2012 оны Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц орон тоог батлах тухай 190 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад шинээр ажилд орох болон албан тушаал дэвшүүлэн ажиллуулахад мөрдөх нийтлэг журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 2015 оны А/668 дугаар захирамж, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Ажлын байр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Үйл ажиллагааны мониторингийн хэлтсийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Алтангэрэлийн Энхтүвшин, Мэдээлэл, технологи хариуцсан мэргэжилтэн Сүрэнхорлоогийн Эрдэнэболд нарыг Захиргаа, санхүүгийн хэлтэст 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн орон тооны хамт шилжүүлэн ажиллуулсугай.

2. А.Энхтүвшин, С.Эрдэнэболд нарын үр дүнгийн гэрээнд зохих өөрчлөлт оруулахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

3. А.Энхтүвшин, С.Эрдэнэболд нарын цалинг зохих журмын дагуу олгохыг ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА Б.БАДРАЛ



\\zaa088\ZAA\3CX\Ya.Gantuяa\alban bicheg\tushaal 2015.docx

1110300465